



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/640

Есөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр 240624/04-526 дугаар гэрээт Халиун, Цогт, Цээл, Чандмань, Эрдэнэ сумдад 11 ширхэг инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Золзаяа (Орон нутгийн өмчийн газрын ашиглалт зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)

Б.Батхуяг (Хүйсийн говь цэцэг нуурын сав газрын захиргааны газрын доорх усны нөөц хяналт шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Халиун, Эрдэнэ, Чандмань, Цогт, Цээл сумдын Засаг дарга

Л.Чинзориг ("Гранд холдинг" ХХК-ын гүйцэтгэх захирал)

Нарийн бичгийн дарга: Э.Пүрэвдорж (Хүнс, хөдөө аж ахуйн газрын малын бэлчээр, тэжээл, усан хангамж хариуцсан мэргэжилтэн)

2. Худгийг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсаны дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Т.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг паспортжуулан бүртгэж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ